



**ТӨВ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**

2021 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 06

Зуунмод сум

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Д.МӨНХБААТАР ТАНАА**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 05 -р хуралдааны тэмдэглэлд:

Хэлэлцсэн нь 5:

Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын үйл ажиллагааны талаар газрын дарга М.Отгонбатын мэдээллийг хэлэлцээд

Шийдвэрлэсэн нь:

Төв аймгийн газар тариалан бүхий сумдад атар газар хагалах, хаврын уринш хийхдээ эргэлтийн талбайгаа нэмэгдүүлж хагалах зэрэг хууль бус үйлдэл гаргаж байгаа талаар иргэдийн гомдол их гарч байгаа тул холбогдох мэргэжлийн байгууллгуудтай хамтран ажлын хэсэг томилон 2021 оны 3-р улиралд багтаан хэмжилт хийж холбогдох арга хэмжээ авах.

Иргэнд газар өмчлөхтэй холбоотойгоор тухайн сумдын иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зураглалыг сумынх нь “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-нд тусгуулах ажлыг зохион байгуулан, арга зүйн зөвлөгөө өгч, хэрэгжилтийг бүрэн хангуулах, төлөвлөгөөнд тусгагдаагүй газрыг иргэн, ААН-д олгохгүй байх.

Сумдын газрын даамлуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, газрын даамалгүй сумдыг яаралтай томилох ажлыг зохион байгуулах зэргээр хүний нөөцийн асуудлыг анхаарч ажиллах.

Зуунмод суманд 2020 онд бүтээн байгуулалтаар ашиглалтад орсон ундны усны нөөцийн сангийн барилга, байгууламжийн усан хангамжийн угсралтын ажилд эвдрэл гарч байгаа тул хяналт тавьж, эвдрэлийг арилгуулах талаар хариуцсан байгууллагад чиглэл өгөх.

Алтанбулаг, Аргалант, Баянчандмань, Сэргэлэн, Эрдэнэ сумдын нутагт газар өмчилсөн хүний тоо тухайн сумын иргэдийн тооноос илүү бөгөөд цаашид ч эдгээр сумдад Улаанбаатар болон харьяаллын бус иргэд газар өмчлөх явдал эрчимжих хандлагатай байгаа тул өөр хот, аймаг, сумдын газар өмчилсөн иргэдэд тэдэнд төрийн үйлчилгээг хэрхэн үзүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын асуудлыг яаж шийдвэрлэх зэрэг дагалдаж гарах асуудлыг төлөвлөн иргэнд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулах.

Бэлчээрийн газрыг зүй зохистой ашиглах, хамгаалах, байгалийн унаган төрхийг хадгалж, хамгаалах болон МАА-н үйлдвэрлэл хөгжүүлэх зорилгоор аймаг, сумын тусгай

0100011

хэрэгцээнд авсан газруудыг “Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар” мэдээллийн санд бүртгүүлэх ажлыг зохион байгуулж, ИТХ, Тэргүүлэгчдээс баталсан шийдвэрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллах гэжээ.

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД

